



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 13 өдөр

Дугаар A/781

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а, 29.2, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын” 2.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний IX хуралдааны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хурал, захиргааны байгууллагын бодлого шийдвэр, зохион байгуулж байгаа ажлыг иргэд, олон нийтэд мэдээлэх зорилгоор “Иргэн танаа” сонинг 26 мянган ширхэг хэвлүүлж тараах, “Монголын Үнэн” сонин захиалгын үнэ, “Эрдэнэт таймс” сэтгүүлийн 2018 оны 12 дугаар сарын дугаарт “ Орхон аймгийн 2018 оны онцлох үйл явдал, бүтээн байгуулалт”-ын талаар мэдээлэл нийтлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд шаардагдах 21800000 /Хорин нэгэн сая найман зуун мянган/ төгрөгийг 2018 оны хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсөл хөтөлбөрийн “Иргэн танаа” сонин хэвлүүлэх зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

“ ИРГЭН ТАНАА” СОНИН ХЭВЛҮҮЛЭХ, “МОНГОЛЫН ҮНЭН”
 СОНИН ЗАХИАЛАХ, “ЭРДЭНЭТ ТАЙМС” СЭТГҮҮЛД
 МАТЕРИАЛ НИЙТЛҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ



№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэгж, тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Орон нутгийн хурал, захиргааны байгууллагын бодлого шийдвэр, зохион байгуулж байгаа ажлыг иргэд, олон нийтэд мэдээлэх зорилгоор “Иргэн танаа” сонинг бэлтгэж, хэвлүүлэх	26.000 ширхэг /А3 хэмжээтэй, 4 нүүр шохойтой цаас/	257 төгрөг	6700000
2	“Монголын Үнэн” сонин захиалгын үнэ	2018 оны 1-12 сар хүртэл / улирал бүр 100 ширхэг/		7033000
3	“Эрдэнэт таймс” сэтгүүлийн 2018 оны 12 дугаар сарын дугаарт “Орхон аймгийн 2018 оны онцлох үйл явдал, бүтээн байгуулалт”-ын талаар мэдээлэл нийтлэх	1000 ширхэг /А4 хэмжээтэй/, шохойтой цаас/	8000 төгрөг	8000000
	Нийт			21800000